

“ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН ТУХАЙ АЖЛЫН ТАЙЛАН


2024.09.03

Дархан-Уул аймаг

2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрийг эх хэлний өдөр болгон зарласан билээ.

Энэ хүрээнд бүх нийтээр эх хэлний өдрийг угтан Монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, хос бичигтэн болох, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагууд эх хэлээ сурталчлах, түүгээр бахархах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн эх хэл, соёл, түүх, зан заншил, өв уламжлалын тухай мэдээ мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлэг, арга хэмжээг зохион байгуулах ажлыг жил болгон уламжлал болгон зохион байгуулдаг билээ.

1. Соёлын 6 байгууллага “Эх хэлний өдөр”-өөр нийт 8 арга хэмжээнд 312 хүнийг хамруулж ажилласан. Үүнд: Төв номын сан 1 үйл ажиллагаанд 32 хүн, Хүүхдийн номын ордон 2 үйл ажилгаанд 128 хүн, Шарын гол, Орхон, Хонгор сумын Соёлын төвүүд 5 арга хэмжээнд 152 хүнийг тус тус хамруулсан байна. Тайланг 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр гарган тайлагнасан.



Зураг 1. Аймгийн соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь ту өдрийн хүрээнд мэндчилгээ дэвшүүлж зураг хуудас бэлтгэж яам, агентлагаас гаргасан сурталчилгаа цахим шэйрлэн, харьяа соёлын байгууллагуудад тус өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай чиглэлийг хүргүүлсэн. /2024.09.01/



Зураг 2. Аймгийн төв номын сан тус өдрийн хүрээнд ”ЕБС-ийн 32 сурагчдын дунд “Эх хэл, Зөв уншлага танин мэдэхүй “АХА” тэмцээн зохион байгуулав.



Зураг 3. Хүүхдийн номын ордон 4 дүгээр сургуулийн номын санчийн урилгаар эх хэл, түүх соёл, үндэсний бичгээр хэвлэгдсэн номоор үзэсгэлэн гаргалаа. Мөн ордонд тус өдрөөр сэдэвчилсэн номын үзэсгэлэнг зохион байгуулж 96 хүнийг хамруулжээ.



Зураг 4. Хүүхдийн номын тус өдрийн хүрээнд “Эх хэл бидний бахархал” шүлгийн уралдааныг зохион байгуулж 32 хүүхдийг хамруулсан.



Зураг 5. Шарын гол сумын соёлын төв нь тус өдрийн хүрээнд сумын хүүхэд, залуучуудын дунд “Орел Мис” арга хэмжээг зохион байгуулж.....хүүхдийг хамруулсан.



Зураг 6. Орхон сумын соёлын төв нь тус өдрийн хүрээнд сумын хүүхэд, багачуудад “Амттай уншлага”, “Уламжлалт тоглоом наадгай” боловсролын хөтөлбөрөөр үйлчлэв.



Зураг 7. Орхон сумын соёлын төв нь сумын иргэд, уншигчдад зөөврийн номын сангийн үйлчилгээгээр үйлчиллээ.



Зураг 8. Хонгор сумын соёлын төв нь тус өдрөөр хүүхдийн уран зохиолын номын, бийрэн бичлэгийн үзэсгэлэн гаргаж 51 хүүхэд үзэж сонирхсон.